

Шалгалт, туршилт

1. Үрийг хүлээлгэн өгөх үед шалгаж хүлээн авна. Шалгах үед няцарсан, норсон, сав баглаа боодол нь гэмтсэн ялгаж цэвэрлэж зөрүү тоо ширхэгийг хэмжээгээр нь акт үйлдэж хохирлыг үрээр болон тендерт нийлүүлэх санал болгосон мөнгөн дүнгийн зөрүүгээр хохирлыг барагдуулна.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Нийлүүлэгдэх үр нь Монгол улсын байгаль, цаг уур, хөрсний шинж чанар, онцлогт тохирч нутагшсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан сортын эрлийз үр байна.
2. Нийлүүлэх хэмх хүлэмжийн үр (Хэмхийн үр) нь MNS-2367-2001, стандартын шаардлагыг хангасан байна.
3. Тендерт оролцогчид нь дараах материалыг тендерийн хамт ирүүлнэ. Үүнд:
Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар заавал ирүүлнэ. Үүнд:
 - 3.1. Тендерт оролцогчийн санал болгосон үрийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг /үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, зураг, сертификат г.м/ ирүүлнэ.
 - 3.2. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанарын шаардлага хангаж байгааг нотлох а) барааны гарал үүсэл, б) чанар в) ургамал хорио цээрийн гэрчилгээний хуулбарыг албан ёсны орчуулгын товчоогоор орчуулуулж ирүүлнэ.
 - 3.3. Нийлүүлэгдэх үрийн үйлдвэрлэгч нь үйлдвэрлэгч орны эрх бүхий байгууллагаас олгосон үр үржүүлэх эрх бүхий хуулийн этгээд байх ба энэ тухай баримт, нотолгоо ирүүлнэ. Албан ёсны орчуулгатай байна.
 - 3.4. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанар, стандартын шаардлага хангасан эсэх талаарх Монгол улсын итгэмжлэгдсэн лабораторын байгууллагын шинжилгээний дүн, түүнд үндэслэсэн таримал ургамал, хорио цээрийн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж ирүүлнэ.
 - 3.5. Тарих үрийн технологи, зөвлөмж, үйлдвэрлэгчийн танилцуулга

Техникийн тодорхойлолт

Өргөст хэмхийн үр 104,000 (нэг зуун дөрвөн мянга) ширхэгээс доошгүй, төсөв 200 сая /хоёр зуун сая/ төгрөг

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)

		тодорхойлолтыг бичнэ үү.)	
1	<p>Ерөнхий үзүүлэлтүүд</p> <p>1.1 Таримлын нэр: Хэмх</p> <p>1.2 1.2 Гарал үүсэл</p> <p>1.3 1.3 Үйлдвэрлэсэн он, сар, өдөр:</p> <p>/2023/</p>		
2	<p>Үзүүлэлт</p> <p>2.1 Таримлын сорт: Монгол улсад нутагцсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан Өвлийн улиралд Монгол улсад тариалагдаж тогтвортой ургац өгч байгаа тухай холбогдох мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллагын тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>2.2 Сортын онцлог. High wire production буюу хязгааргүй есөлттэй, өндөр ургацтай, сүүдэрлэлтэд тэсвэртэй, хүйтэнд тэсвэртэй, 4 улирлын хүлэмжинд тариалах боломжтой сортын өндөр чанартай үр байна.</p> <p>2.2.Үрийн чанарын шаардлага: Улсын үрийн MNS-2367-2001 стандартын шаардлагыг хангасан байна.</p> <p>Үүнд: -Соёололтын хувь 98 хувиас доошгүй -Цэвэршилтийн хувь 99 хувиас доошгүй</p> <p>Өвчин, хортон шавжинд нэрвэгдээгүй байна.</p>		
3	<p>Савлагаа:100, 1000 ширхэгээр савлагдсан байна.</p>		
4	<p>Таримал ургамлын үрийн үнэ</p> <p>Нэгжийн үнэ /ширхэг/</p>		
5	<p>Нийлүүлэх үрийн хэмжээ /ширхэгээр/</p>		